

**“ЗОРЧИГЧИЙН ХООЛ БЭЛТГЭХ ЗОРИУЛАЛТ БҮХИЙ КАТЕРИНГИЙН БАРИЛГЫГ
БАРЬЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙН КОНЦЕССЫН ГЭРЭЭНД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2020 оны 3 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

Энэхүү “Зорчигчийн хоол бэлтгэх зориулалт бүхий катерингийн барилгыг барьж, үйлчилгээ үзүүлэх төсөл”-ийн концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, “Зорчигчийн хоол бэлтгэх зориулалт бүхий катерингийн барилгыг барьж, үйлчилгээ үзүүлэх төсөл”-ийн концессын гэрээний 5.3 дахь заалт, Скайкатеринг ХХК-ийн 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 20/41 дугаар албан тоотой ирүүлсэн хүсэлтийг үндэслэн нэг талаас Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар /цаашид “Эрх бүхий этгээд” гэх/-ын дарга Б.Баярсайхан;

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Скайкатеринг” ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Болормаа /цаашид “Концесс эзэмшигч” гэх/ нар доорх нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1.1. “Зорчигчийн хоол бэлтгэх зориулалт бүхий катерингийн барилгыг барьж, үйлчилгээ үзүүлэх төсөл”-ийн концессын гэрээний 1.9 дэх заалт дахь “Концесс эзэмшигч нь төслийн барилгыг 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө барьж дуусган, ашиглалтад оруулсан байна.” гэснийг “Концесс эзэмшигч нь төслийн барилгыг 2020 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө барьж дуусган, ашиглалтад оруулсан байна.” гэж өөрчлөн найруулав.

ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Энэхүү нэмэлт гэрээгээр нэмэлт өөрчлөлт оруулсан заалтуудаас бусад концессын гэрээний зохицуулалт нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

2.2. Энэхүү нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд концессын гэрээний салшгүй хэсэг байна.

2.3. Энэхүү нэмэлт гэрээ нь адил хүчинтэй 3 хувь үйлдэгдсэн бөгөөд концессын гэрээний хугацаанд хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

Гарын үсэг:

Нэр: Б.Баярсайхан
Албан тушаал: Үндэсний хөгжлийн
газрын дарга
Тамга:



**КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

Гарын үсэг:

Нэр: М.Болормаа

Албан тушаал: Гүйцэтгэх захирал
Тамга:

